



ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

"Гүйцэтгэх удирдлагын
үйл ажиллагааны журам" батлах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.13, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрмийн 1.2.2, 3.2.7.6, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 225 дугаар тогтоолын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрдэнэс Монгол" ХХК, түүний охин, хараат компани, харьяа хуулийн этгээдийн баримтлах "Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг "Эрдэнэс Монгол" ХХК, түүний охин, хараат компани, харьяа хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/, гүйцэтгэх удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Дотоод аудитын алба (С.Мөнхчулуун)-нд даалгасугай.

ДАРГА



Ш.МӨНХЦЭРЭН



ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журам нь Компанийн тухай хууль, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрэм болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үндэслэн "Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн охин, хараат компани, харьяа хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлагыг тодорхойлох, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, цалин урамшууллын хэмжээг тогтоох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, гэрээг дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг "Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн охин, хараат компани, харьяа хуулийн этгээд дагаж мөрдөнө.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

2.1. Энэхүү журамд тусгасан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. "нэгдэл" гэж "Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин, хараат компани, харьяа хуулийн этгээд бүхэлд нь;

2.1.2. "хуулийн этгээд" гэж төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийг;

2.1.3. "гүйцэтгэх удирдлага" гэж Эрдэнэс Монгол ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагыг;

2.1.4. "бизнес төлөвлөгөө" гэж компанийн тухайн жилд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажил, үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, борлуулалтын орлого, зардал, ашиг болон үйл ажиллагаа явуулахад шаардагдах нөөц зэрэг эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, үр өгөөжийг тодорхойлон "Эрдэнэс Монгол" ХХК-аас баталсан баримт бичгийг;

2.1.5. "гүйцэтгэл" гэж тайлант хугацаанд бизнес төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэхээр төлөвлөсөн үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт болон эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, үр ашгийн үзүүлэлтийн хэрэгжилт буюу биелэлтийн хувийг;

2.1.6. "гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт" гэдэг нь төлөвлөсөн зорилго үр дүнд хүрсэн эсэхийг хэмжих тоон болон чанарын үр дүнгээр илэрхийлэгдэх үзүүлэлтийг;

2.1.7. "авбал зохих оноо" гэж гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт бүрээр харгалзуулан өгч буй дээд оноог;

2.1.8. "гүйцэтгэлийг үнэлэх" гэж гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт бүрээр гүйцэтгэлийн хувиар харгалзуулан оноо өгөхийг;

2.1.9. "гүйцэтгэлийн үнэлгээ" гэж гүйцэтгэлийн хувь хэмжээнээс хамааруулан өгч буй ерөнхий дүгнэлтийг;

2.1.10. "ХАБЭА" буюу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл,

аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм эдийн засаг, зохион байгуулалт техник, технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ авах, эмчлэхийг;

2.1.11. "байгууллагын соёл" гэж байгууллагын ажлын орчин, ажилчид хоорондын харилцааг илэрхийлдэг нийтлэг үнэт зүйлс, итгэл үнэмшил, хандлага, зан үйл, дадал зуршил, шийдвэр гаргалт зэрэг нэгдсэн зорилгын төлөө хамтран ажиллахад чиглүүлдэг хамтын хэм хэмжээг;

2.1.12. "баримт бичгийн бүрдэл" гэж энэ журмын 6 дугаар бүлэгт заасан тайлан мэдээллийн бүрдүүлбэр, нэмэлт тайлбар, судалгаа тооцоо, нотолгоо мэдээлэл бүхий баримт бичгүүдийг.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

3.1. Гүйцэтгэх удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулж, томилно.

3.2. Гүйцэтгэх удирдлага нь дараах шаардлагыг хангасан байна:

3.2.1. тухайн хуулийн этгээдийн дүрэмд заасан шаардлагыг хангасан байх;

3.2.2. тухайн хуулийн этгээдтэй адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдэд өөрөө болон хамаарал бүхий этгээд нь хувьцаа эзэмшдэггүй байх ("Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлсэн хувьцаа хамаарахгүй);

3.2.3. хамаарал бүхий этгээд төрийн захиргааны болон улс төрийн өндөр албан тушаал эрхэлдэггүй байх;

3.2.4. компанийн засаглал болон чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой бусад мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх;

3.2.5. тэтгэврийн насанд хүрээгүй байх.

3.3. Энэ журмын 3.2-т заасан шалгуурыг хангасан нэр дэвшигчдээс Компанийн тухай хуулийн 81.2-т заасан Нэр дэвшүүлэх хороо (Төлөөлөн удирдах зөвлөлгүй бол "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлагын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг) дараах журмын дагуу сонгон шалгаруулна:

3.3.1. Гүйцэтгэх удирдлагын сонгон шалгаруулах тухай зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон компанийн цахим хуудсаар сонгон шалгаруулалт явагдах өдрөөс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө нийтэд зарлан мэдээлнэ.

3.3.2. Сонгон шалгаруулалтын зард гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, сонгон шалгаруулалтын үе шат, бүртгэх газар, хаяг, хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгана.

3.3.3. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирүүлсэн иргэний материалын бүрдэл, тухайн албан тушаалд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлж, хамгийн өндөр оноо авсан 5 оролцогчийг ярилцлагын шалгалтад оруулна.

3.3.4. Ярилцлагын шалгалтын дүнгээр хамгийн өндөр үнэлгээ авсан 3 оролцогчийн материалыг Нэр дэвшүүлэх хороо (Төлөөлөн удирдах зөвлөлгүй бол ажлын хэсэг)-оос Төлөөлөн удирдах зөвлөл, (байхгүй бол "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлага)-д танилцуулна.

3.3.5. Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлага) хамгийн өндөр үнэлгээ авсан 3 оролцогчоос Гүйцэтгэх удирдлагыг сонгож, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг байгуулна.

3.4. Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний хугацаа 1 жил байна. Гэрээгээр энэхүү журамд заасан нөхцөлөөс гадна байгууллагын кредит карт, хоол, унааны нэмэгдэл, байгууллагын хариуцлагын даатгал, эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн багц үйлчилгээ, хувь хүний хөгжлийн сургалт (менежмент, манлайлал), туршлага судлах гадаад, дотоод томилолтын асуудлыг зохицуулж болно.

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1. "Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл, орлогын түвшин, онцлогоос хамаарч дараах 2 ангилалд хамааруулан, гүйцэтгэлийн үнэлгээнд тавигдах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

4.1.1. Олборлох, боловсруулах үйлдвэрлэл явуулж буй;

4.1.2. "Эрдэнэс Монгол" ХХК, түүний санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулдаг болон бусад.

4.2. Энэ журмын 4.1.1-т заасан "Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын үнэлгээг дараах үндсэн 6 шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

4.2.1. үйлдвэрлэлийн;

4.2.2. үр ашгийн;

4.2.3. санхүүгийн;

4.2.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн;

4.2.5. байгаль орчны;

4.2.6. удирдлагын бусад чиг үүргийн.

4.3. Үйлдвэрлэлийн үзүүлэлтийг дараах байдлаар үнэлнэ:

4.3.1. Уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний биелэлт: Ашигт малтмалын олборлолт, хөрс хуулалтын зохист харьцааны үзүүлэлт, технологийн тээврийн зохион байгуулалт, уулын ажлын батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлангийн харьцуулсан тооцоолоор;

4.3.2. Үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт: Баяжуулсан нүүрс, баяжмал, хаягдал, бохирдлын хэмжээ, эцсийн бүтээгдэхүүний тоо хэмжээ ба төлөвлөгөөний биелэлтийн түвшнээр;

4.3.3. Технологийн горим мөрдөж ажилласан байдал: Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд технологийн горимыг мөрдөж ажилласан эсэх, бүтээгдэхүүний гарцын чанараар;

4.3.4. Тоног төхөөрөмж, техникийн бэлэн байдлын коэффициентын биелэлт: Техник, тоног төхөөрөмжийн ажилд бэлэн байсан цаг болон ажиллавал зохих фонд цагийн харьцаагаар илэрхийлэгдэнэ. Тухайн онд батлуулсан техник тоног төхөөрөмжийн засварын ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөт бус их засварын ажлын тайлангийн гүйцэтгэлээр;

4.4. Үр ашгийн үзүүлэлтийг дараах байдлаар үнэлнэ:

4.4.1. Борлуулалтын орлогын биелэлт: Борлуулалтын орлогын гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөний биелэлтийн түвшнээр;

4.4.2. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийн түвшин: Тус үзүүлэлтийг дараах байдлаар үнэлнэ:

4.4.2.1 Хөрс хуулалтын зардлын өсөлт, бууралт: 1 м.куб хөрс хуулалтын зардал өмнөх онтой харьцуулахад өссөн, буурснаар тодорхойлогдоно.

4.4.2.2 Уулын цулын хөдөлгөхөд зарцуулсан метр куб тутмын төсөвт өртгөөс хэтрэхгүй байх: Уурхайн олборлох үйл ажиллагааны зардлыг нийт хөдөлгөсөн уулын цулын хэмжээнд харьцуулсан нэгжийн өртгөөр хэмжигдэх ба батлагдсан төсөвт өртгөөс ихгүй байх шаардлагыг хангаж буй эсэх тооцооллоор;

4.4.2.3 Нэг тонн тутамд ногдох олборлолтын зардлын түвшин: Уурхайн олборлох үйл ажиллагааны зардлыг олборлосон ашигт малтмалын хэмжээнд хувааж тодорхойлох ба төлөвлөсөн өртгөөс ихгүй байх;

4.4.2.4 Нэг тонн тутамд ногдох боловсруулах зардлын түвшин: Олборлосон ашигт малтмалыг технологийн дагуу нунтаглаж, шигшиж, химийн урвалжийн нөлөөгөөр ашигт агууламжийн хэмжээг нэмэгдүүлэх болон гүйцээн баяжуулахтай холбоотой зардлын түвшнээр.

4.4.3. Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн түвшин: Энэ нь олборлосон ашигт малтмал, боловсруулсан баяжмал, үйлдвэрлэж боловсруулсан эцсийн бүтээгдэхүүний нийлбэр өртгөөр илэрхийлэгдэнэ. Батлагдсан төсөвт өртгөөс ихгүй байх шаардлагыг хангаж буй эсэх тооцооллоор;

4.4.4. Ашигт ажиллагааны түвшин: Энэ нь мөнгөн дүн ба өмнөх тайлант хугацааны харьцуулсан хувь хэмжээ (өсөлт бууралт), төлөвлөгөөний биелэлтийн түвшнээр;

4.4.5. Ерөнхий удирдлагын зардлын гүйцэтгэл: Уурхайн олборлолт, баяжуулалт, боловсруулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй шууд холбоогүй удирдлагын зардлыг оруулж тооцож, хянана. Тайлант оны эхэнд батлагдсан ерөнхий удирдлагын зардлын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулан тухайн зардлын хэтрэлт, хэмнэлтийн хувийн үзүүлэлттээр;

4.4.6. Үндсэн үйл ажиллагааны өртөг ба ерөнхий удирдлагын зардлын харьцааны гүйцэтгэл: Нийт борлуулалтын орлогод эзлэх хувьсах болон тогтмол зардлын харьцаагаар тус тусдаа илэрхийлэгдэх бөгөөд аль төрлийн зардал нь ашигт ажиллагаанд илүү нөлөөлснийг тодорхойлно. Тайлант хугацааны төсвийг батлахад тус харьцаа үзүүлэлтийг баталж, гүйцэтгэлийн үзүүлэлттээр тухайн харьцааг хангаж ажилласан эсэх тооцооллоор.

4.5. Санхүүгийн үзүүлэлтийг дараах байдлаар үнэлнэ:

4.5.1. Өөрийн хөрөнгийн өгөөж өссөн эсэх: Тайлант хугацааны цэвэр ашгийг нийт эздийн өмчид харьцуулсан харьцаагаар хэмжинэ;

4.5.2. Нийт хөрөнгийн өгөөж өссөн эсэх: Тайлант хугацааны цэвэр ашгийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаагаар хэмжинэ;

4.5.3. Өр төлбөр, хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцааны биелэлт:

Компанийн хөрөнгийн бүтэц дэх өр болон өөрийн хөрөнгийн харьцааг хэмжинэ. Өр төлбөрийн харьцаа буурч, өр төлбөрөө барагдуулсан байдлыг үнэлнэ;

4.5.4. Бараа материалын нөөцийн удирдлагын гүйцэтгэл: Тус үзүүлэлтээр үндсэн үйл ажиллагааг явуулахад чухал шаардлагатай технологийн үндсэн материалаас /хүдэр, түлш, тос, сэлбэг, дугуй г.м/ гадна хүдрийн аюулгүйн нөөцийн бүрдүүлэлтийн хэмжээг тогтоож үнэлнэ;

4.5.5. Өр төлбөр, авлагын удирдлагын гүйцэтгэл: Дансны авлагын насжилт, найдваргүй авлагын сан, авлагын тулган баталгаажуулалт, дансны өглөгийн тулган баталгаажуулалт, хөрөнгийн үр ашгийн тооцооллоор.

4.5.6. Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үнэлгээ: Тайлант хугацааны санхүүгийн тайлангийн хөндлөнгийн болон дотоод аудитын дүгнэлт болон өмнөх жилийн санхүүгийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн дагуу зөрчлийг шийдвэрлэсэн байдлаар.

4.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзүүлэлтийг дараах байдлаар үнэлнэ:

4.6.1. ХАБЭА-н зөрчлөөс шалтгаалсан сул зогсолтын хугацаа: Ажлын байранд тавигдах ХАБЭА-н шаардлага, стандарт зөрчигдсөнөөс үүдэн хэвийн үйл ажиллагаа тасалдсан, доголдсон нийт цаг. Үүнд: Эрх бүхий байгууллага, субъектийн зүгээс тавьсан шаардлага, гаргасан шийдвэрийн улмаас доголдсон цагийн тооцоогоор;

4.6.2. ХАБЭА-ны шалтгаантай үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, зөрчлийн тоо: ХАБЭА зөрчигдсөнөөс үүдэн гарсан осол, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдол гарсан эсэхээр;

4.6.3. ХАБЭА-ны зөрчлийн осол, аваарын тоо: ХАБЭА нөхцөл зөрчигдсөнөөс үүдэн гарсан осол, хүний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын үнэлгээгээр;

4.6.4. ХАБЭА-д зарцуулсан зардлын биелэлт: Хууль болон холбогдох эрхзүйн баримт бичгүүдэд заасан зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх төлөвлөгөөний биелэлтээр;

4.6.5. ХАБЭА-ны дадал, хэвшил: ХАБЭА-ны сургалтын давтамж, ажилтнуудын мэдлэг, компанийн дотоод баримт бичгийн бүрдэл, мөрдөх байдлын үнэлгээг хөндлөнгийн үнэлгээний байгууллагуудын тайлан дахь дүгнэлт, компанийн дотоод хяналтын өгсөн үнэлгээ зэрэгт үндэслэсэн үнэлгээгээр.

4.7. Байгаль орчны үзүүлэлтийг байгаль орчны үнэлгээний тайланд үндэслэн үнэлнэ:

4.7.1. Байгаль орчны зөрчлийн үнэлгээ: Байгаль орчны хяналт тавих төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагын шаардлагыг хангасан тухай үнэлгээгээр; (байгаль орчны аудитын үнэлгээг 2 жил тутамд хийдэг)

4.7.2. Ус ашиглалтын тайлангийн үнэлгээ: Нэгж бүтээгдэхүүнд шаардагдах технологийн усны зарцуулалтын бууралт, ус дахин ашиглалтыг сайжруулах талаар хийсэн ажлын тайланд өгсөн мэргэжлийн байгууллагын үнэлгээгээр;

4.7.3. Мод тарих, ойн санг нэмэгдүүлэхээр ажилласан байдал: "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжих талаар хийсэн ажлын гүйцэтгэлээр;

4.7.4. Нөхөн сэргээлтийн байдал: Батлагдсан төлөвлөгөөний дагуу хийсэн нөхөн сэргээлтийн ажлын биелэлтээр.

4.8. Удирдлагын бусад чиг үүргийн үзүүлэлтийг дараах үзүүлэлтээр үнэлнэ:

4.8.1. Байгууллагын соёлын үнэлгээ: Хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар эсхүл "Эрдэнэс Монгол" ХХК-аас ажлын орчин, нийтлэг үнэт зүйлс, итгэл үнэмшил, хандлага, зан үйл, дадал зуршил, шийдвэр гаргалт зэрэг нийтлэг зорилгын төлөө хамтран ажиллахад чиглүүлж буй хамтын хэм хэмжээг үнэлсэн байдлаар;

4.8.2. Хууль тогтоомж, бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлт болон нэгдлийн стратеги төлөвлөгөөнд компанийн үйл ажиллагааг нийцүүлж ажилласан байдал: Төрийн бодлого, холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа дагаж мөрдсөн тухай, Улсын Их хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт, Төлөөлөн удирдах зөвлөл, дотоод аудит болон "Эрдэнэс Монгол" ХХК-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, шийдвэрийг хэрэгжүүлсэн байдлаар;

4.8.3. Маргаан, зөрчил, гомдол, тэдгээрийн шийдвэрлэсэн байдал: Тухайн компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн аливаа эрх зүйн зөрчил, гомдлын тоо, үр нөлөө, тэдгээрийг шийдвэрлэсэн тухай тайлангаар;

4.8.4. Дотоод аудитын зөвлөмж, эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал: Дотоод аудитын өгсөн зөвлөмжийн биелэлт болон эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлангийн үр дүнгээр;

4.8.5. Төслийн үйл ажиллагааны үнэлгээ: Нэгдлийн хэмжээнд мөрдөж буй төслийн үйл ажиллагааны загварчлал, төслийн нэгжийн загварчлалын дагуу төслийн үе шатуудыг зохион байгуулсан байдлаар.

4.9. Энэ журмын 4.1.2-т заасан Эрдэнэс Монгол ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын үнэлгээг дараах үзүүлэлтүүдэд суурилан үнэлнэ:

4.9.1. бизнес төлөвлөгөөний биелэлт;

4.9.2. үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт;

4.9.3. худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт;

4.9.4. батлагдсан техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу үйл ажиллагааг явуулсан байдал;

4.9.5. санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан байдал;

4.9.6. төслийн батлагдсан төсөв, календарчилсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж буй байдал;

4.9.7. хөрөнгө оруулалт, санхүүжилт татах чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажлын тайлан;

4.9.8. аудитлагдсан санхүүгийн тайлангийн үнэлгээ: Тайлант хугацааны болон өмнөх жилийн санхүүгийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн дагуу зөрчлийг шийдвэрлэсэн байдлаар;

4.9.9. төсөл хэрэгжүүлэх болон хэрэгжүүлж буй бүс нутгийн хамтын ажиллагааны үр дүн;

4.9.10. төсөлд оролцогч талуудтай үр дүнтэй харилцаж, мэдээллээр хангах зэргээр төсөлд санаачилгатай оролцож буй байдал.

4.9.11. удирдлагын бусад чиг үүргийн үзүүлэлтийн биелэлтийг дараах үзүүлэлтээр үнэлнэ:

4.9.11.1. байгууллагын соёлын үнэлгээ: Хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар эсхүл "Эрдэнэс Монгол" ХХК-аас ажлын орчин, нийтлэг үнэт зүйлс, итгэл үнэмшил, хандлага, зан үйл, дадал зуршил, шийдвэр гаргалт зэрэг нийтлэг зорилгын төлөө хамтран ажиллахад чиглүүлж буй хамтын хэм хэмжээг үнэлсэн байдлаар;

4.9.11.2. хууль тогтоомж, бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлт болон нэгдлийн стратеги төлөвлөгөөнд компанийн үйл ажиллагааг нийцүүлж ажилласан байдал: Төрийн бодлого, холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа дагаж мөрдсөн тухай, Улсын Их хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт, Нэгдлийн стратеги төлөвлөгөөнд компанийн үйл ажиллагааг нийцүүлэн удирдан зохион байгуулж буй эсэх, Төлөөлөн удирдах зөвлөл болон "Эрдэнэс Монгол" ХХК-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, шийдвэрийг хэрэгжүүлсэн байдлаар;

4.9.11.3. маргаан, зөрчил, гомдол, тэдгээрийн шийдвэрлэсэн байдал: Тухайн компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн аливаа эрх зүйн зөрчил, гомдлын тоо, үр нөлөө, тэдгээрийг шийдвэрлэсэн тухай тайлангаар;

4.9.11.4. дотоод аудитын зөвлөмж, эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал: Дотоод аудитын өгсөн зөвлөмжийн биелэлт болон эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлангийн үр дүнгээр.

ТАВ. ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

5.1. Энэхүү журмын 4.1.1-т заасан олборлох, боловсруулах үйлдвэрлэл явуулж буй нэгдлийн хуулийн этгээдийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд нь дараах харгалзах оноогоор үнэлэх бөгөөд энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан аргачлалыг ашиглана:

Журмын заалт	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо
4.3	Үйлдвэрлэлийн үзүүлэлт	20
4.3.1.	Уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний биелэлт	5
4.3.2	Үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт	5
4.3.3	Технологийн горим мөрдөж ажилласан байдал	5
4.3.4	Тоног төхөөрөмж, техникийн бэлэн байдлын коэффициентын биелэлт	5
4.4	Үр ашгийн үзүүлэлт	20
4.4.1	Борлуулалтын орлогын биелэлт	3
4.4.2	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийн түвшин	5
4.4.3	Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн түвшин	3
4.4.4	Ашигт ажиллагааны түвшин	3
4.4.5	Ерөнхий удирдлагын зардлын гүйцэтгэл	3
4.4.6	Үндсэн үйл ажиллагааны өртөг ба Ерөнхий удирдлагын зардлын харьцааны гүйцэтгэл	3

4.5	Санхүүгийн үзүүлэлт	25
4.5.1	Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) өссөн эсэх	4
4.5.2	Нийт хөрөнгийн өгөөж (ROA) өссөн эсэх	4
4.5.3	Өр төлбөр, хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцааны биелэлт (D/E ratio)	4
4.5.4	Бараа материалын нөөцийн удирдлагын гүйцэтгэл	4
4.5.5	Өр төлбөр, авлагын удирдлагын гүйцэтгэл	4
4.5.6	Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үнэлгээ	5
4.6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзүүлэлт	10
4.6.1	ХАБЭА-ны зөрчлөөс шалтгаалсан сул зогсолтын хугацаа	2
4.6.2	ХАБЭА-ны шалтгаантай үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, зөрчлийн тоо	2
4.6.3	ХАБЭА-ны зөрчлийн осол, аваарын тоо	2
4.6.4	ХАБЭА-д зарцуулсан зардлын биелэлт	2
4.6.5	ХАБЭА-ны дадал, хэвшил	2
4.7	Байгаль орчны үзүүлэлт	10
4.7.1	Байгаль орчны зөрчлийн үнэлгээ	3
4.7.2	Ус ашиглалтын тайлангийн үнэлгээ	2
4.7.3	Мод тарих, ойн санг нэмэгдүүлэхээр ажилласан байдал	1
4.7.4	Нөхөн сэргээлтийн байдал	4
4.8	Удирдлагын бусад чиг үүргийн үзүүлэлт	15
4.8.1	Байгууллагын соёлын үнэлгээ	4
4.8.2	Хууль тогтоомж, бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлт болон Нэгдлийн стратеги төлөвлөгөөнд компанийн үйл ажиллагааг нийцүүлж ажилласан байдал	3
4.8.3	Маргаан, зөрчил, гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал	2
4.8.4	Дотоод аудитын зөвлөмж, эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал	3
4.8.5	Төслийн үйл ажиллагааны үнэлгээ	3
Нийт		100

5.2. Энэхүү журмын 4.1.2-т заасан "Эрдэнэс Монгол" ХХК-ийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулдаг нэгдлийн хуулийн этгээдийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд нь дараах харгалзах оноогоор үнэлэгдэх бөгөөд өгөгжүү журмын хоёрдугаар хавсралтад заасан аргачлалыг ашиглана:

Журмын заалт	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо
4.9.1	Бизнес төлөвлөгөөний биелэлт;	5

4.9.2	Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт ;	15
4.9.3	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	10
4.9.4	Батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу үйл ажиллагаа явуулсан байдал	10
4.9.5	Санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан байдал	10
4.9.6	Төслийн батлагдсан төсөв, календарчилсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж буй байдал	10
4.9.7	Хөрөнгө оруулалт, санхүүжилт татах чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажлын тайлан	10
4.9.8	Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үнэлгээ	5
4.9.9	Төсөл хэрэгжүүлэх болон хэрэгжүүлж буй бүс нутгийн хамтын ажиллагааны үр дүн	5
4.9.10	Төсөлд оролцогч талуудтай үр дүнтэй харилцаж, мэдээллээр хангах зэрэг төсөлд санаачилгатай оролцож буй байдал.	5
4.9.11	Удирдлагын бусад чиг үүргийн үзүүлэлтийн биелэлт	15
4.9.11.1	Байгууллагын соёлын үнэлгээ	5
4.9.11.2	Хууль тогтоомж, бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлт болон Нэгдлийн стратеги төлөвлөгөөнд компанийн үйл ажиллагааг нийцүүлж ажилласан байдал	3
4.9.11.3	Маргаан, зөрчил, гомдол, тэдгээрийн шийдвэрлэсэн байдал	2
4.9.11.4	Дотоод аудитын зөвлөмж, эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал	5
Нийт		100

5.3. Гүйцэтгэл оноог хувь тэнцүүлэн дараах байдлаар тооцно:

5.3.1. гүйцэтгэл 0-79 хувьтай гүйцэтгэсэн тохиолдолд 0 оноо өгнө.

5.3.2. гүйцэтгэл 80 хувиас их буюу тэнцүү 100 хувиас бага бол үнэлгээний оноог хувь тэнцүүлэн тооцно.

5.3.3. гүйцэтгэл 100 хувиас их буюу тэнцүү бол харгалзах оноог бүтэн өгнө.

5.4. Гүйцэтгэлийн үнэлгээнд харгалзах дүгнэлт нь гүйцэтгэлийн үнэлгээний авбал зохих онооноос хамаарах бөгөөд дараах байдлаар дүгнэнэ:

№	Гүйцэтгэлийн үнэлгээ	Дүгнэлт
1	90-100 оноо	Сайн
2	80-89 оноо	Хангалттай
3	70-79 оноо	Сайжруулах шаардлагатай

4	70-аас доош	Хангалтгүй
---	-------------	------------

5.5.Компанийн үйл ажиллагаанаас хамаарахгүй давагдашгүй хүчин зүйл, онцгой нөхцөл байдлын улмаас гүйцэтгэл хангалтгүй байгаа тохиолдолд тухайн арга хэмжээний биелэлтийг гүйцэтгэлийн үнэлгээнд оруулалгүй хасаж тооцно.

5.6.Нэгдлийн хуулийн этгээдийн Гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээг энэхүү журмын дагуу "Эрдэнэс Монгол" ХХК-ийн нэгжүүд үйл ажиллагааны чиглэлийн дагуу хийж, Нэгдсэн стратеги, бизнес хөгжлийн газар үнэлгээг нэгтгэнэ.

5.7.Энэхүү журмын 5.6-д заасан нэгтгэсэн үнэлгээг нэгдлийн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлага)-д хүргүүлнэ.

5.8."Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээг энэхүү журамд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлд үнэлнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ, ДҮГНЭХ

6.1."Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын улирал тутмын үнэлгээ нь үйл ажиллагааг сайжруулах, шаардлагатай үүрэг даалгавар өгөх зорилготой байна.

6.2.Гүйцэтгэх удирдлага томилогдсоноос хойших 2 улирлын үнэлгээ нь хагас жилийн үнэлгээ болох ба 4 улирлын үнэлгээний дундаж нь гүйцэтгэх удирдлагын гэрээний гүйцэтгэлийн үнэлгээ болно.

6.3."Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага гүйцэтгэлийн үнэлгээний тайланг улирал тутам улирлын дараа сарын 30-ний дотор дараах тайлан мэдээллийг хавсаргаж ирүүлнэ:

6.3.1.батлагдсан бизнес төлөвлөгөө, түүний хэрэгжилт;

6.3.2.уулын ажлын батлагдсан төлөвлөгөө, тайлан;

6.3.3.техник, тоног төхөөрөмж засварын ажлын төлөвлөгөө, тайлан;

6.3.4.байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан;

6.3.5.аудитлагдсан санхүүгийн тайлан;

6.3.6.төслийн төлөвлөгөө, тайлан;

6.3.7."Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Дотоод аудитын алба болон бусад хяналт шалгалтын байгууллагуудаас хийсэн аудит, хяналт шалгалтын тайлан;

6.3.8.ХАБЭА-ны тайлан;

6.3.9.эрсдэлийн удирдлагын тайлан.

6.4."Эрдэнэс Монгол" ХХК улирлын үнэлгээний тайлантай танилцаж, "Хангалтгүй" үнэлэгдсэн тохиолдолд холбогдох газар, хэлтсүүд чиг үүргийн дагуу үүрэг даалгавар, зөвлөмжийг албан бичгээр хүргүүлнэ.

6.5.Энэ журмын 6.3-т заасан тайлан мэдээг заасан хугацаанд ирүүлээгүй, эсвэл хугацаа хоцроосон тохиолдолд харгалзах үнэлгээний шалгуур үзүүлэлтийн оноог хасах, тэглэх үндэслэл болно.

ДОЛОО. ЦАЛИН, УРАМШУУЛАЛ, ХАРИУЦЛАГА

7.1. Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалинг "Эрдэнэс Монгол" ХХК, түүний хуулийн этгээдийн санхүүгийн чадавх үйл ажиллагааны онцлог, цар хүрээ зэргийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлага) энэхүү журамд заасан аргачлалын дагуу тогтооно.

7.1.1. "Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдийн Гүйцэтгэх удирдлагын цалинг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хамтын хэлэлцээр, "Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам"-д үндэслэн тухайн компани, хуулийн этгээдийн нийт хөрөнгийн хэмжээ, ажиллагсдын тоо, тайлант жилийн цэвэр ашгийн хэмжээнээс харгалзсан дараах 3 итгэлцүүрийг тодорхойлно:

7.1.1.1 Нийт хөрөнгийн хэмжээний итгэлцүүр (Кх):

№	Хөрөнгийн хэмжээ	Кх
1	1.0 тэрбум төгрөг хүртэл	0.7
2	1.0-10.0 тэрбум төгрөг хүртэл	0.9
3	10.0-100.0 тэрбум төгрөг хүртэл	1.2
4	100.0-1.0 их наяд төгрөг хүртэл	1.6
5	1.0 их наяд төгрөгөөс дээш хүртэл	2.0

7.1.1.2 Нийт ажиллагсдын тооны итгэлцүүр (Ат):

№	Нийт ажиллагсдын тооны	Ат
1	100 хүртэл ажиллагсадтай	0.7
2	100 -500 хүртэл ажиллагсадтай	0.9
3	500-1000 хүртэл ажиллагсадтай	1.2
4	1000-1500 хүртэл ажиллагсадтай	1.6
5	1500-аас дээш ажиллагсадтай	2.0

7.1.1.3 Цэвэр ашгийн хэмжээний итгэлцүүр (Ка):

№	Цэвэр ашгийн хэмжээ	Ка
1	100.0 сая төгрөг хүртэл	0.7
2	100.0 -500.0 сая төгрөг хүртэл	0.9
3	500.0-1.0 тэрбум төгрөг хүртэл	1.2
4	1.0-100.0 тэрбум төгрөг хүртэл	1.6
5	100.0 тэрбум төгрөгөөс дээш	2.0

*Тухайн "Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдийн нийт хөрөнгийн хэмжээ, ажиллагсдын тоо, тайлант жилийн цэвэр ашгийн хэмжээг жилийн эцсийн аудит хийгдсэн тайлан тэнцэлд тусгагдсан тоогоор авна.

7.1.2. "Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдийн Гүйцэтгэх удирдлагын сарын цалинг энэхүү журмын 7.1.1-д тодорхойлсон итгэлцүүрийг ашиглан, дараах томъёогоор бодож гаргана.

$$\text{Цалин} = 9 \times K_0 \frac{(K_x + A_t + K_a)}{3}$$

K_0 - Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

7.1.3. Гүйцэтгэх удирдлагын гэрээг дүгнэх үед тайлант жилийн ажлын үр дүнг харгалзан үндсэн цалинг жил бүр шинэчлэн тогтооно.

7.1.4. Энэхүү журамд заасны дагуу итгэлцүүрээр тогтоогдсон цалинг зах зээл дээр өрсөлдөхүйц хэмжээнд хүргэх, үр дүнг сайжруулах зорилгоор "Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдийн Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний биелэлт, компанид нэвтрүүлсэн шинэлэг арга барил, шинэ дэвшилтэт техник, технологи, зах зээлд гаргасан шинэ нэрийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, санхүүгийн үр дүн, стратегийн ач холбогдол зэргийг харгалзан 1.5-3 дахин нэмэгдүүлэн тогтоож болно. Нэмэгдүүлэх гол үндэслэл нь гүйцэтгэлийн үнэлгээ байна.

7.1.5. Энэхүү журмын 7.1.4-т заасан нэмэгдүүлэх хэмжээг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлагын хувьд "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, нэгдлийн хуулийн этгээдийн хувьд "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлага тогтооно.

7.1.6. Гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийн үр дүнгийн үнэлгээ "Сайжруулах шаардлагатай", "Хангалтгүй" гэж үнэлэгдсэн тохиолдолд цалинг бууруулж, "Сайн", "Хангалттай" үнэлэгдсэн тохиолдолд өсгөж болно.

7.2. Гүйцэтгэх удирдлагад урамшуулалт цалин олгох, шагналд тодорхойлох асуудлыг тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал (байхгүй бол "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлага) шийдвэрлэнэ.

7.2.1. Гүйцэтгэх удирдлагын үнэлгээг үндэслэн хагас жил, бүтэн жилээр дор дурдсан хэмжээгээр урамшуулж болно.

7.2.1.1 хагас жилийн гүйцэтгэлээр урамшуулах хэмжээ

№	Үнэлгээ	хэмжээ
1	2 улирал дараалан "сайн" үнэлгээ авсан бол	3 хүртэлх сарын үндсэн цалин
2	1 улирал "сайн", 1 улирал "хангалттай" үнэлгээ авсан бол	2 хүртэлх сарын үндсэн цалин
3	2 улирал дараалан "хангалттай" үнэлгээ авсан бол	1 хүртэлх сарын үндсэн цалин

7.2.1.2 бүтэн жилийн гүйцэтгэлээр урамшуулах хэмжээ

№	Үнэлгээ	хэмжээ
1	4 улирал дараалан "сайн" үнэлгээ авсан бол	6 хүртэлх сарын үндсэн цалин
2	2 улирал "сайн", 2 улирал "хангалттай" үнэлгээ авсан бол	5 хүртэлх сарын үндсэн цалин
3	4 улирал "хангалттай" үнэлгээнээс дээш үнэлгээ авсан бол	4 хүртэлх сарын үндсэн цалин

7.3. Удирдлагад дараах нөхцөлд урамшуулал олгохгүй:

7.3.1. осол аваарын улмаас хүний амь нас эрсэдсэн, хүнд гэмтэл учирсан, их хэмжээний хохирол гарсан;

7.3.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж ноцтой зөрчсөн нь тогтоогдсон;

7.3.3.тухайн жилийн санхүүгийн аудитын дүгнэлтээр хязгаарлалттай дүгнэлт авсан;

7.3.4.тухайн жилд хуанлийн 90 болон түүнээс доош хоног ажилласан.

7.4.Гүйцэтгэх удирдлага 2 улирал дараалан 70-аас доош үнэлгээ авч, "Хангалтгүй" дүгнэлт авсан тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах, гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах бөгөөд уг асуудлыг тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлага) шийдвэрлэнэ.

НАЙМ. ГЭРЭЭГ СУНГАХ, ДУУСГАВАР БОЛГОХ, ЦУЦЛАХ

8.1.Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ 70%-аас дээш үнэлэгдсэн тохиолдолд гэрээг 1 жилээр сунгана. Гэрээний сунгалтыг бичгээр хийнэ.

8.2.Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээ нь дараах үндэслэлээр дуусгавар болно:

8.2.1.гэрээний хугацаа дуусгавар болж, цаашид сунгахгүй болсон;

8.2.2.Төлөөлөн удирдах зөвлөлөөс эсвэл хувьцаа эзэмшигчдийн хурлаас Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг зогсоох, гэрээг цуцлах шийдвэр гаргасан;

8.2.3.Гүйцэтгэх удирдлагын хүсэлтээр гэрээг цуцалсан;

8.3.Гүйцэтгэх удирдлагын санаачилгаар дараах тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно:

8.3.1.өвчний улмаас компанийг удирдах чадваргүй болсон;

8.3.2.бусад хүндэтгэх шалтгаан бий болсон;

8.4.Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээг дараах үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцална:

8.4.1.Гүйцэтгэх удирдлага компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлага)-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээг хэтрүүлсэн;

8.4.2.Гүйцэтгэх удирдлага нь хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлээгүй эсхүл биелүүлсэн ч ажлын гүйцэтгэлийн дүн сайжраагүй;

8.4.3.хариуцсан хуулийн этгээд, төслийн нэгжийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, үрэгдүүлсэн;

8.4.4.Гүйцэтгэх удирдлага онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд тусгайлан заасан хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах ноцтой зөрчил гаргасан;

8.4.5.Гүйцэтгэх удирдлага 2-оос дээш улирал дараалан 70-аас доош үнэлэгдсэн;

8.4.6.хууль болон гэрээнд заасан бусад үндэслэл.

8.5."Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага албан тушаалаас чөлөөлөгдсөн, Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ нь хугацаанаасаа өмнө цуцлагдсан тохиолдолд төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, гэрээг дуусгавар болгоно.

8.6. Энэ журмын 8.4-д заасан үндэслэлээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлага)-өөс томилсон этгээд нь өмч хөрөнгийн эзэмшилт, ашиглалтын байдлыг тогтоож, компанийн эд хөрөнгийн тооллого явуулан бүртгэж, дараагийн Гүйцэтгэх удирдлагад хүлээлцүүлнэ.

8.7. Гүйцэтгэх удирдлага нь гүйцэтгэл хангалтгүй үнэлэгдсэн, гэрээ, хууль тогтоомж, Компанийн дүрэм, дотоод журмыг зөрчсөн үйлдэл эс үйлдэхүй гаргасан тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлага)-өөс зөрчлийн шинж байдал, гэм буруу зэргийг нь харгалзан сануулах, үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, энэхүү гэрээг цуцлах сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна.

ЕС. БУСАД

9.1. Төлөөлөн удирдах зөвлөлгүй нэгдлийн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага нь дараах нөхцөлд "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх удирдлагад мэдэгдэж, харьяалагдах компанийн хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу баталгаажуулна:

- 9.1.1. гадаад томилолтоор ажиллах;
- 9.1.2. ажлын 5-аас дээш хоногийн чөлөө авах;
- 9.1.3. ээлжийн амралт авах.

9.2. Төлөөлөн удирдах зөвлөлтэй нэгдлийн хуулийн этгээд нь энэхүү журмын 9.1-д заасан баталгаажуулалтыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс авах бөгөөд энэ талаар "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлагад мэдэгдэнэ.

-- оОо --

Хавсралт 1. Журмын 5.1-т тусгасан шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн хэмжүүр, үнэлгээний аргачлал

№	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Үнэлгээний хэмжүүр	Авбал зохих оноо	Гүйцэтгэлийн хэмжүүр	Үнэлгээний аргачлал
Нэг. Үйлдвэрлэлийн үзүүлэлт			20		
1.1	Уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний биелэлт	Ашигт малтмалын олборлолт, хөрс хуулалтын зохист харьцааны үзүүлэлт, технологийн тээврийн зохион байгуулалт, батлагдсан уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлангийн харьцуулсан тооцооллоор	5	гүйцэтгэл/ төлөвлөгөө	
1.2	Үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт	Баяжуулсан нүүрс, хүдрийн баяжмал, хаягдал, бохирдлын хэмжээ, эцсийн бүтээгдэхүүний тоо хэмжээ ба төлөвлөгөөний биелэлтийн түвшнээр	5	гүйцэтгэл/ төлөвлөгөө	Биелэлт 100% дээш - 5 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 2.5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
1.3	Технологийн горим мөрдөж ажилласан байдал	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд технологийн горимыг мөрдөж ажилласан эсэх бүтээгдэхүүний гарцын чанараар	5	чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүний хэмжээ/ үйлдвэрлэлийн төлөвлөгөөт хэмжээ	
1.4	Тоног төхөөрөмж, техникийн бэлэн байдлын коэффициентын биелэлт	Техник, тоног төхөөрөмжийн ажилд бэлэн байсан цаг болон ажиллавал зохих фонд цагийн харьцаагаар илэрхийлэгдэнэ. Тухайн онд батлуулсан техник тоног төхөөрөмжийн засварын ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөт бус их засварын ажлууд хийгдсэн байдлын тайлангийн гүйцэтгэлээр.	5	техник бэлэн байсан цаг/ажиллавал зохих фонд цаг	
Хоёр. Үр ашгийн үзүүлэлт			20		
2.1	Борлуулалтын орлогын биелэлт	Борлуулалтын орлогын гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөний биелэлтийн түвшнээр	3	гүйцэтгэл/ төлөвлөгөө	Биелэлт 100% дээш - 3 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 1.5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо

2.2	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийн түвшин	Хөрс хуулалтын зардлын өсөлт бууралт, Уулын цулын хөдөлгөхөд зарцуулсан метр куб тутмын төсөвт өртгөөс хэтрэхгүй байх, Нэг тонн тутамд ногдох олборлолтын зардал, Нэг тонн тутамд ногдох боловсруулах зардал	5	гүйцэтгэл/ төлөвлөгөө	Өртгийг бууруулсан эсхүл төлөвлөгөөний дагуу бол - 5 оноо Зардлыг 5%-аас ихгүй хэтрүүлсэн бол - 2.5 оноо Зардлыг 5%-аас их хэтрүүлсэн бол - 0 оноо
2.3	Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн түвшин	Олборлосон ашигт малтмал, боловсруулсан баяжмал, үйлдвэрлэж боловсруулсан эцсийн бүтээгдэхүүний нийлбэр өртгөөр илэрхийлэгдэнэ. Батлагдсан төсөвт өртгөөс ихгүй байх шаардлагыг хангаж буй эсэх тооцооллоор	3	гүйцэтгэл/ төлөвлөгөө	Өртгийг бууруулсан эсхүл төлөвлөгөөний дагуу бол - 3 оноо Зардлыг 5%-аас ихгүй хэтрүүлсэн бол - 1.5 оноо Зардлыг 5%-аас их хэтрүүлсэн бол - 0 оноо
2.4	Ашигт ажиллагааны түвшин	Энэ нь мөнгөн дүн ба өмнөх тайлант хугацааны харьцуулсан хувь хэмжээ (өсөлт бууралт), төлөвлөгөөний биелэлтийн түвшинээр	3	төлөвлөгөөний биелэлт/ оны эхний төлөвлөгөө биелэлт	Оны эхэн үеийн үзүүлэлтээс өссөн бол - 3 оноо Оны эхэн үеийн үзүүлэлттэй тэнцүү бол - 1.5 оноо Оны эхэн үеийн үзүүлэлтээс буурсан бол - 0 оноо
2.5	Ерөнхий удирдлагын зардлын гүйцэтгэл	Уурхайн олборлолт, баяжуулалт, боловсруулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй шууд холбоогүй удирдлагын зардлыг оруулж тооцож, хянана. Тайлант оны эхэнд батлагдсан ерөнхий удирдлагын зардлын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулан тухайн зардлын хэтрэлт, хэмнэлтийн хувийн үзүүлэлтээр	3	гүйцэтгэл/ төлөвлөгөө	Өртгийг бууруулсан эсхүл төлөвлөгөөний дагуу бол - 3 оноо Зардлыг 5%-аас ихгүй хэтрүүлсэн бол - 1.5 оноо Зардлыг 5%-аас их хэтрүүлсэн бол - 0 оноо
2.6	Үндсэн үйл ажиллагааны өртөг ба Ерөнхий удирдлагын зардлын харьцааны гүйцэтгэл	Нийт борлуулалтын орлогод эзлэх хувьсах болон тогтмол зардлын харьцаагаар тус тусдаа илэрхийлэгдэх бөгөөд аль төрлийн зардал нь ашигт ажиллагаанд илүү нөлөөлснийг тодорхойлно. Тайлант хугацааны төсвийг батлахад тус харьцаа үзүүлэлтийг баталж, гүйцэтгэлийн үзүүлэлтээр тухайн харьцааг хангаж	3	гүйцэтгэл/ төлөвлөгөө	Биелэлт 100% дээш - 3 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 1.5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо

		ажилласан эсэх тооцооллоор;			
Гурав. Санхүүгийн үзүүлэлт			25		
3.1	Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) өссөн эсэх	Тайлант хугацааны цэвэр ашгийг нийт эздийн өмчид харьцуулсан харьцаагаар хэмжинэ.	4	Өгөөж / оны эхэн үеийн өгөөж	Өгөөж өссөн бол - 4 оноо Өгөөж өмнөх онтой тэнцүү бол - 2 оноо Өгөөж буурсан бол - 0 оноо
3.2	Нийт хөрөнгийн өгөөж (ROA) өссөн эсэх	Тайлант хугацааны цэвэр ашгийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаагаар хэмжинэ	4	Өгөөж / оны эхэн үеийн өгөөж	Өгөөж өссөн бол - 4 оноо Өгөөж өмнөх онтой тэнцүү бол - 2 оноо Өгөөж буурсан бол - 0 оноо
3.3	Өр төлбөр, хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцааны биелэлт	Компанийн хөрөнгийн бүтэц дэх өр болон өөрийн хөрөнгийн харьцааг хэмжинэ. Өр төлбөрийн харьцаа буурч, өр төлбөрөө барагдуулсан байдлыг үнэлнэ.	4	Харьцаа/ оны эхэн үеийн харьцаа	Өр төлбөрийн харьцаа буурсан бол - 4 оноо ӨТ/Харьцаа өмнөх онтой тэнцүү бол - 2 оноо ӨТ/Харьцаа өссөн бол - 0 оноо
3.4	Бараа материалын нөөцийн удирдлагын гүйцэтгэл	Тус үзүүлэлтээр үндсэн үйл ажиллагааг явуулахад чухал шаардлагатай технологийн үндсэн материалаас /хүдэр, түлш, тос, сэлбэг, дугуй г.м/ гадна хүдрийн аюулгүйн нөөцийн бүрдүүлэлтийн хэмжээг тогтоож үнэлнэ	4	гүйцэтгэл/ төлөвлөгөө	Биелэлт 100% дээш - 4 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 2 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
3.5	Өр төлбөр, авлагын удирдлагын гүйцэтгэл	Дансны авлагын насжилт, найдваргүй авлагын сан, авлагын тулган баталгаажуулалт, дансны өглөгийн тулган баталгаажуулалт, хөрөнгийн үр ашгийн тооцооллоор	4	Хэрэгжилтийн хувиар	Авлага, өр төлбөр барагдуулах төлөвлөгөө гаргуулж ажиллах ба тус төлөвлөгөөний биелэлт 100% дээш-4 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 2 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
3.6	Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үнэлгээ	Тайлант хугацааны санхүүгийн тайлангийн хөндлөнгийн болон дотоод аудитын дүгнэлт болон өмнөх жилийн санхүүгийн аудитаар өгсөн акт, албан	5	Хэрэгжилтийн хувиар	Биелэлт 100% дээш-5 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 2.5 оноо

		шаардлага, зөвлөмжийн дагуу зөрчлийг шийдвэрлэсэн байдлаар			Биелэлт 79% доош - 0 оноо
Дөрөв. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзүүлэлт			10		
4.1	ХАБЭА-н зөрчлөөс шалтгаалсан сул зогсолтын хугацаа	Ажлын байранд тавигдах ХАБЭА-н шаардлага, стандарт зөрчигдсөнөөс үүдэн хэвийн үйл ажиллагаа тасалдсан, доголдсон нийт цаг. Үүнд: эрх бүхий байгууллага, субъектийн зүгээс тавьсан шаардлага, гаргасан шийдвэрийн улмаас доголдсон цагийн тооцоогоор	2	Шалтгаант сул зогсол гарсан эсэхээр	Үйл ажиллагаа тасалдсан сул зогсолт гараагүй бол - 2 оноо ХАБЭА-н шаардлага, стандартаас шалтгаалсан хэвийн үйл ажиллагаа тасалдсан, доголдсон цаг гарсан бол - 0 оноо
4.2	ХАБЭА-н шалтгаантай үйлдвэрийн осол, хурц хордлого, зөрчлийн тоо	ХАБЭА зөрчигдсөнөөс үүдэн гарсан осол, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдлын тоогоор	2	Зөрчил гарсан эсэхээр	Зөрчил гараагүй, зөрчил гарсан ч шуурхай эрсдэл үүсгээгүй бол -2 оноо Зөрчил гарч, арга хэмжээ авалгүй эрсдэл үүсгэсэн бол - 0 оноо
4.3	ХАБЭА-н зөрчлийн осол, аваарын тоо	ХАБЭА нөхцөл зөрчигдсөнөөс үүдэн гарсан осол, хүний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын үнэлгээгээр	2	Зөрчил гарсан эсэхээр	Зөрчил гараагүй бол-2 оноо Зөрчил гарсан бол - 0 оноо
4.4	ХАБЭА-д зарцуулсан зардлын биелэлт	Хууль болон холбогдох эрхзүйн баримт бичгүүдэд заасан зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх төлөвлөгөөний биелэлтээр	2	гүйцэтгэл/ төлөвлөгөө	Биелэлт 100% дээш-2 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 1 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
4.5	ХАБЭА-н дадал, хэвшил	ХАБЭА-н сургалтын давтамж, ажилтнуудын мэдлэг, компанийн дотоод баримт бичгийн бүрдэл, мөрдөх байдлын үнэлгээг хөндлөнгийн үнэлгээний байгууллагуудын тайлан дахь дүгнэлт, компанийн дотоод хяналтын өгсөн үнэлгээ зэрэгт үндэслэсэн үнэлгээгээр	2	гүйцэтгэл/ төлөвлөгөө	Биелэлт 100% дээш-2 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 1 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
Тав. Байгаль орчны үзүүлэлт			10		
5.1	Байгаль орчны зөрчлийн үнэлгээ	Байгаль орчны хяналт тавих төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагын	3	Үнэлгээний хувиар	Үнэлгээ 100%-3 оноо Үнэлгээ 80-100% хувь тэнцүүлэн

		шаардлагыг хангасан тухай үнэлгээгээр; /байгаль орчны аудитын үнэлгээ 2 жил тутамд хийдэг/			тооцно. Үнэлгээ 80% бол - 1.5 оноо Үнэлгээ 79% доош - 0 оноо
5.2	Ус ашиглалтын тайлангийн үнэлгээ	Нэгж бүтээгдэхүүнд шаардагдах технологийн усны зарцуулалтын бууралт, ус дахин ашиглалтыг сайжруулах талаар хийгдсэн ажлын тайланд өгсөн мэргэжлийн байгууллагын үнэлгээгээр	2	Үнэлгээний хувиар	Үнэлгээ 100% - 2 оноо Үнэлгээ 80-100% хувь тэнцүүлэн тооцно Үнэлгээ 80% бол - 1 оноо Үнэлгээ 79% доош - 0 оноо
5.3	Мод тарих, ойн санг нэмэгдүүлэхээр ажилласан байдал	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжих талаар хийгдсэн ажлын гүйцэтгэлээр	1	гүйцэтгэл/ төлөвлөгөө	Биелэлт 100% дээш - 1 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 0.5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
5.4	Нөхөн сэргээлтийн байдал	Батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдсэн нөхөн сэргээлтийн ажлын биелэлтээр	4	гүйцэтгэл/ төлөвлөгөө	Биелэлт 100% дээш - 4 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 2 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
Зургаа. Удирдлагын бусад чиг үүргийн үзүүлэлт			15		
6.1	Байгууллагын соёлын үнэлгээ	Хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар эсхүл "Эрдэнэс Монгол" ХХК-аас ажлын орчин, нийтлэг үнэт зүйлс, итгэл үнэмшил, хандлага, зан үйл, дадал зуршил, шийдвэр гаргалт зэрэг нийтлэг зорилгын төлөө хамтран ажиллахад чиглүүлж буй хамтын хэм хэмжээг үнэлсэн байдлаар	4	Үнэлгээний хувиар	Үнэлгээ 100% - 4 оноо Үнэлгээ 80-100% хувь тэнцүүлэн тооцно Үнэлгээ 80% бол - 2 оноо Үнэлгээ 79% доош - 0 оноо
6.2	Хууль тогтоомж, бодлого шийдвэр, нэгдлийн стратеги төлөвлөгөөнд компанийн үйл ажиллагааг нийцүүлж ажилласан байдал	Төрийн бодлого, холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа дагаж мөрдсөн тухай, Улсын Их хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт, Нэгдлийн стратеги төлөвлөгөөнд үйл ажиллагааг нийцүүлж хэрэгжүүлсэн байдал, ТУЗ, дотоод аудит болон "Эрдэнэс Монгол"	3	Хэрэгжилтийн хувиар	Биелэлт 100% - 3 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 1.5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо

		ХХК-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, шийдвэрийг хэрэгжүүлсэн байдлаар			
6.3	Маргаан, зөрчил, гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал	Тухайн компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн аливаа эрх зүйн зөрчил, гомдлын тоо, үр нөлөө, тэдгээрийг шийдвэрлэсэн тухай тайлангаар	2	Шийдвэрийн хэрэгжилтийн хувиар	Биелэлт 100% - 2 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 1 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
6.5	Дотоод аудитын зөвлөмж, эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал	Дотоод аудитын өгсөн зөвлөмжийн биелэлт болон эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлангийн үр дүнгээр	3	Хэрэгжилтийн хувиар	Биелэлт 100% - 3 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 1.5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
6.6	Төслийн үйл ажиллагааны үнэлгээ	Нэгдлийн хэмжээнд мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагааны загварчлал, төслийн нэгжийн загварчлалын дагуу төслийн үе шатуудыг зохион байгуулсан байдлаар	3	Хэрэгжилтийн хувиар	Биелэлт 100% - 3 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 1.5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
		НИЙТ	100		

Хаесралт 2. Журмын 5.2-т тусгасан шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн хэмжүүр, үнэлгээний аргачлал

№	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Үнэлгээний хэмжүүр	Авбал зохих оноо	Гүйцэтгэлийн хэмжүүр	Үнэлгээний аргачлал
1	Бизнес төлөвлөгөөний биелэлт	Батлагдсан бизнес төлөвлөгөөний зорилтын биелэлтийн түвшнээр	5	Гүйцэтгэл/ Батлагдсан төлөвлөгөө	Биелэлт 100% дээш - 5 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 2.5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
2	Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	Батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн түвшнээр	15	Гүйцэтгэл/ Батлагдсан төлөвлөгөө	Биелэлт 100% дээш - 15 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 7.5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
3	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	Батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн түвшнээр	10	Гүйцэтгэл/ Батлагдсан төлөвлөгөө	Биелэлт 100% дээш - 10 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
4	Батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу үй ажиллагаа явуулсан байдал	Батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн түвшнээр	10	Гүйцэтгэл/ Батлагдсан төлөвлөгөө	Биелэлт 100% дээш - 10 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
5	Санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан байдал	Батлагдсан төсвийн биелэлтийн түвшнээр	10	Үнэлгээний хувиар	Үнэлгээ 100% - 10 оноо Үнэлгээ 80-100% хувь тэнцүүлэн тооцно Үнэлгээ 80% бол - 5 оноо Үнэлгээ 79% доош - 0 оноо
6	Төслийн батлагдсан төсөв, календарчилсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж буй байдал	Батлагдсан төсвийн биелэлтийн түвшнээр	10	Гүйцэтгэл/ Батлагдсан төлөвлөгөө	Биелэлт 100% дээш - 10 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
7	Хөрөнгө оруулалт, санхүүжилт татах чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажлын тайлан	Ажлын үр дүнгийн тайлангийн үнэлгээгээр	10	Үнэлгээний хувиар	Үнэлгээ 100% - 10 оноо Үнэлгээ 80-100% хувь тэнцүүлэн тооцно Үнэлгээ 80% бол - 5 оноо Үнэлгээ 79% доош - 0 оноо
8	Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үнэлгээ	Тайлант хугацааны болон өмнөх жилийн санхүүгийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн дагуу зөрчлийг шийдвэрлэсэн байдлаар	5	Үнэлгээний хувиар	Үнэлгээ 100% - 5 оноо Үнэлгээ 80-100% хувь тэнцүүлэн тооцно Үнэлгээ 80% бол - 2.5 оноо Үнэлгээ 79% доош - 0 оноо

9	Төсөл хэрэгжүүлэх болон хэрэгжүүлж буй бүс нутгийн хамтын ажиллагааны үр дүн	Ажлын үр дүнгийн тайлангийн үнэлгээгээр	5	Хэрэгжилтийн хувиар	Биелэлт 100% - 5 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 2.5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
10	Төсөлд оролцогч талуудтай үр дүнтэй харилцаж, тэднийг мэдээллээр хангах зэргээр төсөлд санаачилгатай оролцож буй байдал.	Ажлын үр дүнгийн тайлангийн үнэлгээгээр	5	Үнэлгээний хувиар	Үнэлгээ 100% - 5 оноо Үнэлгээ 80-100% хувь тэнцүүлэн тооцно Үнэлгээ 80% бол - 2.5 оноо Үнэлгээ 79% доош - 0 оноо
11	Удирдлагын бусад чиг үүргийн үзүүлэлтийн биелэлт		15		
11.1	Байгууллагын соёлын үнэлгээ	Хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар эсхүл "Эрдэнэс Монгол" ХХК-аас ажлын орчин, нийтлэг үнэт зүйлс, итгэл үнэмшил, хандлага, зан үйл, дадал зуршил, шийдвэр гаргалт зэрэг нийтлэг зорилгын төлөө хамтран ажиллахад чиглүүлж буй хамтын хэм хэмжээг үнэлсэн байдлаар	5	Үнэлгээний хувиар	Үнэлгээ 100% - 5 оноо Үнэлгээ 80-100% хувь тэнцүүлэн тооцно Үнэлгээ 80% бол - 2.5 оноо Үнэлгээ 79% доош - 0 оноо
11.2	Хууль тогтоомж, бодлого шийдвэр, нэгдлийн стратеги төлөвлөгөөнд компанийн үйл ажиллагааг нийцүүлж ажилласан байдал	Төрийн бодлого, холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа дагаж мөрдсөн тухай, Улсын Их хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт, Нэгдлийн стратеги төлөвлөгөөнд үйл ажиллагааг нийцүүлж хэрэгжүүлсэн байдал, ТУЗ, дотоод аудит болон "Эрдэнэс Монгол" ХХК-аас өгсөн үүрэг	3	Хэрэгжилтийн хувиар	Биелэлт 100% - 3 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 1.5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо

		даалгаврын биелэлт, шийдвэрийг хэрэгжүүлсэн байдлаар			
11. 3	Маргаан, зөрчил, гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал	Тухайн компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн аливаа эрх зүйн зөрчил, гомдлын тоо, үр нөлөө, тэдгээрийг шийдвэрлэсэн тухай тайлангаар	2	Үнэлгээний хувиар	Үнэлгээ 100% - 2 оноо Үнэлгээ 80-100% хувь тэнцүүлэн тооцно Үнэлгээ 80% бол - 1 оноо Үнэлгээ 79% доош - 0 оноо
11. 4	Дотоод аудитын зөвлөмж, эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал	Дотоод аудитын өгсөн зөвлөмжийн биелэлт болон эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлангийн үр дүнгээр	5	Хэрэгжилтийн хувиар	Биелэлт 100% - 5 оноо Биелэлт 80-100% хувь тэнцүүлэн тооцно Биелэлт 80% бол - 2.5 оноо Биелэлт 79% доош - 0 оноо
Нийт			100		